

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
2020 ОНЫ 03 ДУГААР САРЫН 1 ДЭХ ДОЛОО ХОНОГИЙН
АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ**

Нэг. Зарим статистик үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Тухайн долоо хоног	Жилийн эхнээс өссөн дүн	Өмнөх онтой харьцуулахад
1	Нийт төрөлт	31	418	-50
2	Амьд төрөлт	31	419	-51
3	Амьгүй төрөлт	0	1	0
4	Дутуу төрөлт	0	8	- 8
5	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	14	+2
6	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	2	-2
7	Эхийн ноцтой хүндрэл	0	0	0
8	Төрөлхийн гажиг	0	5	+3
9	Гэрийн төрөлт	0	0	1

Хоёр. Томуу, томуу төст өвчний мэдээ

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 9 дүгээр долоо хоногт нийт 2918 хүн үйлчлүүлсний 209 (7.1 %) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 1.7 %- иар өссөн үзүүлэлттэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (103)- ийн дотор буюу 21.3 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 0.2 %- иар өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 559 дуудлагын 111 (19.8%)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 0.4 %- иар буурсан үзүүлэлттэй байна.

Гурав. Нийгмийн эрүүл мэнд

9 цагийн радиод Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх мэдээлэл өгсөн.

COVID -19 болзошгүй халдварын тохиолдлын үед хэрхэн ажиллах талаар төсөөллөл боловсруулсан.

Аймгийн Засаг даргын тамгын газарт , Цагдаагийн газарт ,Мэргэжлийн Хяналтын газарт COVID -19 болзошгүй халдварын тохиолдол аймагт бүртгэгдвэл хэрхэн ажиллах ,дэлгэх орны төсөөллийг боловсруулан 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн № 229 албан тоотоор хүргүүлсэн .Мөн МХГ-т Эрүүл мэндийн ажиглалтын байранд ажиллах хариуцах байгууллагын хуваарийг хүргүүлсэн.

**“КОД-9” СЭДЭВТ ДАСГАЛ СУРГУУЛИЛТААР ГАРДАН ҮЙЛДЛИЙГ
ГҮЙЦЭТГЭЛЭЭ.**

Аймгийн Засаг даргын орлогч Ш.Хавылын баталсан удирдамжаар 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Нисэх буудалд Эрүүл мэндийн газар, Зооноз өвчин судлалын төв, Нэгдсэн эмнэлэг, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Шипагер, Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтарч цагийн байдал зарлаж “Код-9” сэдэвт бүрэн хэмжээний нийт 70 гаруй төлөөлөл оролцож, дасгал сургуулилт хийлээ.

Сургуулилт Монгол улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын дагуу мэргэжлийн байгууллагууд шуурхай мэдээлэл солилцож, баталсан удирдамжийн дагуу үүргээ гүйцэтгэж, салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллалаа. Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг хамтран шуурхай хариу арга хэмжээ авах 6 багийг бэлтгэн зорчигч, эмнэл зүйн эмч, тархвар судлаач, лаборант, ариутгагчийн дүрийн тоглолт хийж, гардан үйлдлийг тухайн сэжигтэй тохиолдол гарсан нөхцөлд хэрхэн ажиллахыг харуулж гүйцэтгэсэн.

Дасгал сургуулилтын дараа явц, гүйцэтгэл, үр дүн, алдаа, ололтын талаар дүнгийн хурал хийж, цаашид анхаарах асуудлыг зөвлөлдөн, дотооддоо асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг зөвлөлдсөн.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИГЛАЛТЫН БАЙРАНД АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГЫН
ХУВААРЬ**

№	Ажиглалтын байршил	Хариуцах эрүүл мэндийн байгууллага
1	Тухайн өвчлөл гарсан бүс нутгаас ирсэн тохиолдол байх үед	
	Авто тээврийн төв Орны тоо:8	Мейрим өрхийн эрүүл мэндийн төв
	Сансар сувилал Орны тоо:14	Сансар сувилал өөрсдөө
2	Сэжигтэй тохиолдолын бүртгэгдсэн үед	
	Мэргэжил сургалтын үндэсний төв Орны тоо:100	Бугат сумын Эрүүл мэндийн төв
	Ахлах сургуулийн дотуур байр Орны тоо:50	Жансая, Раушан өрхийн эрүүл мэндийн төвүүд

ХЯНАЛТЫН ПОСТОНД АЖИЛЛАСАН БАЙДАЛ

COVID-2019 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор бүх шатны сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаатайгаар зогсоосонтой холбогдуулан Аймгийн Засаг даргын №А/118 захирамжийг үндэслэн сургуулийн эмч нарыг чадваржуулах сургалт зохион байгуулж, мэргэжлийн зөвөлгөө өгч, хяналтын постонд хуваарь гарган ажиллуулж байна.

Аймгийн Автотээврийн төвд 2020 оны 03 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 17:00 цагийн байдлаар Цэнгэл транс ХХК-ийн хот хооронд Өлгий-Улаанбаатар чиглэлд зорчсон 2 автобусны 104 зорчигч, Бүгд Найрамдах Казахстан улсын “АБИ АСТАНА” компанийн улс хооронд Өлгий-Нур-Султан-Караганда чиглэлд зорчсон 1 автобусны 48 зорчигч, Аман авто транс ХХК-ийн хот хооронд Өлгий-Улаанбаатар чиглэлд зорчсон 1 автобусны 49 зорчигч, Газрын Од ХХК-ийн хот хооронд Өлгий-Улаанбаатар чиглэлд зорчсон 1 автобусны 48 зорчигч нийт 5 автобусны 249 зорчигч нарт эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн биеийн халууныг хэмжиж үзлэг хийлгэж, хуваарийн гарган, тэдний үйл ажилд хяналт тавин ажиллаж байгаа юм.

ШУУРХАЙ ШТАБ АЖИЛЛУУЛЖ БАЙНА

Аймгийн Эрүүл мэндийн газрын албан хаагч нар 24 цагийн бэлэн байдалтай Өлгий-Ховд чиглэлийн авто замын пост, Автотээврийн төвд дэмжлэгт хяналт, тандалт хийж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт байрлаж буй төв штаб болон Эрүүл мэндийн газарт шуурхай штаб, хариуцлагатай жижүүрээр ажиллаж, мэдээ мэдээллийг холбогдох газарт уламжилж байна. 99493103, 70424299-утсаар мэдээлэл авч өгч байна.

Коронавирусийн болзошгүй халдвараас урьдчилан сэргийлэх, шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудад шаардлагатай хамгаалах хувцас, халдваргүйжүүлэх бодисын нөөц бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж, байгууллагаасаа 100 ш маск, хувиасаа 100 мянган төгрөгийн хандив өгсөн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Нургулан өгсөн.

БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ ХҮРЭЭНД

Эрүүл мэндийн газар 2020 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 14:00 цагаас 22:00 цаг хүртэл халдваргүйтгэлийн бэлэн байдлыг хангахад үүрэгжүүлэх, зураглал гаргах, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт эрх зүйн баримт, тушаал зааврыг танилцуулах сургалт хийж, эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал корона вирусийн халдвараас сэргийлэх чиглэлээр шуурхай хариу авах багийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаа.

Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Зооноз өвчин судлалын төвийн холбогдох ажлын хэсэг Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвийн Коронавируст халдвар/ COVID-19 /-ын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах өрөө, ойрын хавьталуудыг байрлуулан ажиглалтанд авах байр болон эмнэлгийг нүүлгэн шилжүүлэх байрны зохион байгуулалтыг хийж, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөц, судалгааг хийж, бэлэн байдлыг хангуулахад шаардагдах төсвийн тооцоог гарган, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хамгаалах хувцас өмсөх, тайлах, хог хаягдлыг цуглуулах, хадгалах, устгах чиглэлээр зөвлөгөө, зааварчилга өгч ажилласан.

Эмнэлгийг нүүлгэн шилжүүлэх байрыг тустай гаргаж бэлэн байдлыг хангуулж хаягжуулалт хийсэн ба шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар үүрэг чиглэл өгч ажиллаж ирлээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРААС НИСЭХ БУУДАЛД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Сургалтад мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүд оролцож нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрхэн ажиллах талаар санал солилцож, мөн Эрүүл мэндийн Сайдын А/135 дугаар тушаалыг танилцуулж, Нисэх буудлын тусгаарлах өрөөний бэлэн байдал, эрүүл ахуйн бүсийн хэрэгжилтэд МХГ, Нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төвтэй хамтарч мэргэжил арга зүйгээр хангалаа.

Шинэкоронавирусын болзошгүй халдварын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн тохиолдолд шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд ЭМГ нь ӨЭМТөвүүдийн эмч нартай уулзалт хийж, санал солилцож, үүрэг даалгавар өгөгдлөө.

Шинэ коронавирүсийн болзошгүй халдварын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн тохиолдолд шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд ЭМГ-т Бугат сумын ЭМТ-ийн эрхлэгч, ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, санал солилцсоны үндсэнд тус төвийн зарим эмнэлгийн мэргэжилтнүүдийг дайчлан ажиллахаар шийдвэрлэв.

Манай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн ортой 6 эмнэлгийн захирал, холбогдох албан тушаалтнуудыг хүлээн авч, болзошгүй нөхцөл байдал үүсч, аймгийн Нэгдсэн эмнэлгийг бүрэн тусгаарласан тохиолдолд 2 дахь шатны эмнэлгийн хэвийн тусламж үйлчилгээг дээрх хувийн эмнэлгүүдээр дамжуулан хэрхэн зохион байгуулах, тэд ямар байдлаар оролцох боломжтой талаар санал солилцож, стационарын үйл ажиллагааг бүрэн гүйцэтгэх боломжтой гэж үзэж, амбулаторийн үйл ажиллагааг өрхийн эрүүл мэндийн төвүүдээр гүйцэтгүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Шуурхай хариу арга хэмжээний 6 багийн гишүүдийн хурлыг зохион явууллаа. Байна.

Дөрөв. Эмнэлгийн тусламжийн хэлтэс

**ЭМГ-ЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН
ХЭЛТЭС**